

Ерөнхийлөгч
Томас С.Монсон



Их Эзэнд хайраар ҮЙЛЧИЛ

Есүс Христ “учир нь хэн амиа аврахыг хүснэ, тэр нь амиа алдах болно. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр нь амиа аварна” (Лук 9:24) хэмээн заасан билээ.

Ерөнхийлөгч Томас С.Монсон хэлсэн үгэндээ “Бид бусдад үйлчлэхэд өөрсдийгөө зориулахгүй бол бидний амьдралын зорилго өчүүхэн юм гэдгийг Аврагч бидэнд захиж хэлсэн. Зөвхөн өөрийнхөө төлөө амьдардаг хүмүүс эцэстээ уруудан доройтож, чухамдаа амиа алддаг бол бусдад үйлчлэхийн төлөө өөрийгөө умартадаг хүмүүс дэвжин хөгжиж, үүнийхээ ачаар амиа авардаг гэдэгт би итгэдэг” гэжээ.¹

Ерөнхийлөгч Монсоны хэлсэн үйлчлэлийн талаарх дараах эшлэлүүд нь хожмын үеийн гэгээнтнүүдэд тэд бол Их Эзэний мутар бөгөөд бусдад итгэлтэйгээр үйлчилдэг тэдгээрийг мөнх оршихуйн адислалууд хүлээдэг гэдгийг сануулдаг билээ.

Ариун сүм дэх үйлчлэл

“Бид хөшигний цаана байгаа хүмүүсийн өмнөөс ёслолуудыг гүйцэтгэснээр агуу үйлчлэл хийдэг. Ихэнх тохиолдолд бид хэний төлөө ёслол гүйцэтгэж байгаагаа мэддэггүй. Бид ямар нэгэн талархал эсвэл бидний санал болгож буй зүйлийг хүлээж авч байгаа эсэх баталгааг хүсэн хүлээдэггүй. Гэсэн хэдий ч бид

үйлчилдэг бөгөөд ингэснээр бид өөр ямар ч хүчин чармайлтаас ирдэггүй тэрхүү зүйлийг олж авдаг билээ: бид үнэндээ Сион уулан дээрх аврагчид болдог. Аврагч маань Өөрийн амьдралыг бидний төлөө золиосолсны адилаар бид ч гэсэн мөн хэр хэмжээндээ, дэлхий дээрх хэн нэгэн хүн тэдний төлөө ямар нэгэн зүйл хийхгүй л бол мөнхийн аялал руу өсч хөгжих боломжгүй тэдгээр хүмүүсийн төлөө ариун сүмд тэднийг төлөөлөх ёслолуудыг гүйцэтгэдэг юм.”²

Бид Их Эзэний мутар билээ

“Ах, эгч нар аа, бидний анхаарал халамж, урам дэм, тусламж дэмжлэг, тайтгаруулал, нинжин сэтгэл хэрэгтэй байгаа бидний гэр бүлийн гишүүд, найз нөхөд, таньдаг, таньдаггүй хүмүүс эргэн тойронд маань хаа сайгүй байна. Бид бол дэлхий дээрх Их Эзэний хүүхдүүдэд үйлчилж, тэднийг өргөх үүрэгтэй Түүний мутар болсон хүмүүс юм. Тэрээр бидний хүн нэг бүрд найдлага тавьдаг. . . .

“Бидний дуудагдсан үйлчлэл бол Их Эзэн Есүс Христэд үйлчлэх үйлчлэл мөн.”³

Аврагчийн адилаар үйлчлэх нь

“Миний сүмд хийх ёстой зүйлүүдээ та нар мэднэ; учир нь миний хийхийг та нарын харсан

тэр ажлуудыг та нар түүнчлэн хийх болно; учир нь миний хийснийг та нар харсан, бүр түүнийг та нар хийх болно” хэмээн Их Эзэн амилсныхаа дараа шинэ дэлхийд тунхагласан [3 Нифай 27:21].

“Бид “сайныг үйлдэж явсан . . . Назарын Есүсийн” адил бусдад үйлчилснээр тэдний амьдралыг адисалдаг [Үйлс 10:38]. Дэлхий дээрх Бурханы хүүхдүүдэд үйлчилснээр бид Тэнгэр дэх Эцэгтээ үйлчилдэг. Тэрээр үүнээс ирдэг баяр баяслыг олж авах боломжоор биднийг адисалдаг билээ.”⁴

Үйлчлэх хэрэгцээ

“Үйлчлэх боломж бидэнд олгох хэрэгтэй. Бид идэвхгүй эсвэл дахин идэвхтэй болох талаар эргэлзэж байгаа гишүүдэд туслах арга замыг залбирч эрэлхийлэх ёстой. Боломжтой үйлчлэл хийхийг тэднээс хүсэх нь дахин идэвхтэй болоход нь тэдэнд хэрэгтэй хөшүүрэг байж болно. Гэвч энэ талаар тусалж чадах удирдагчид заримдаа ийнхүү туслахдаа дурамжхан байдаг. Бид хүмүүс өөрчлөгдөж чадна гэдгийг санах хэрэгтэй. Тэд муу зуршлуудаа орхиж чадна. Тэд гэм нүглүүдээ наманчилж чадна. Тэд зохистой санваартан болж чадна. Тэд Их Эзэнд хичээнгүйлэн үйлчилж чадна.”⁵

Хийх хэрэгтэй бүх зүйлүүдээ бид хийж байна уу?

“Дэлхийд бидний тусламж хэрэгтэй байна. Хийх хэрэгтэй бүх зүйлүүдээ бид хийж байна уу? Бид ерөнхийлөгч Жонн Тэйлорын “та нар дуудлагаа эрхэмлэн биелүүлэхгүй аваас үүргээ биелүүлснээр аврах боломжтой байсан тэдгээр хүмүүсийн төлөө Бурхан та бүгдтэй хариуцлага тооцох болно” хэмээн хэлсэн үгсийг санаж байна уу. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Жонн Тэйлор* (2001), 164. Өргөн босгох хөл, атгах гар, урам зориг өгөх сүнс, сэнхрүүлэх зүрх, аврах сүнснүүд байна. Мөнх амьдралын адислалууд та бүгдийг хүлээж байна. . . . үйлчлэлийн талбарт үзэгчид биш харин оролцогчид байх боломж та нарт байна.”⁶

ЭШЛЭЛҮҮД

1. “Өнөөдөр би хэн нэгний төлөө юу хийв?” *Лиахона*, 2009 оны 11-р сар, 85.
2. “Биднийг дахин уулзтал” *Лиахона* 2009 оны 5-р сар, 113–14.
3. “Өнөөдөр би хэн нэгний төлөө юу хийв?” 86, 87.
4. “Аврагчийн үйлчлэх дуудлага” *Лиахона* 2012 оны 8-р сар, 5

5. “Бусдыг ирээдүйд ямар болсон байхаар нь харж сур,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 68
6. “Үйлчлэх хүсэлтэй мөн зохистой байх нь,” *Лиахона*, 2012 оны 5-р сар, 69
7. *Teaching, No Greater Call: Сайн мэдээг заах удирдамж* (1999), 12

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

“Хэрэв танд Христийнхтэй адил хайр байгаа бол та сайн мэдээг заахад илүү сайн бэлтгэгдэх болно. Та бусдад Аврагчийг таньж мэдэн Түүнийг дагахад нь туслахаар Сүнсээр өдөөгдөх болно.”⁷ Айлчилж очдог хүмүүсээ хайрлах хайраа нэмэгдүүлэхийн төлөө залбирах талаар бод. Тэднийг хайрлахдаа Христийнхтэй адил хайрыг хөгжүүлснээр Их Эзэн болон айлчилж очдог хүмүүстээ утга учиртай арга замаар үйлчлэх илүү боломжтой болох болно.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД

Үйлчлэл хийсэн зун

Элизабет Блайт

Би гадаадын нэгэн оронд онцгой анхаарал халамж хэрэгтэй хүүхдүүдтэй ажиллан, нэг зуныг өнгөрөөсөн юм. Би анх тэдгээр хүүхдүүдтэй уулзахдаа маш их сандарсан. Би тэдний хэлээр яриагүй ч сүнс намайг тэдэнтэй харилцахад удирдах болно гэдэгт итгэж байлаа. Би хүүхэд бүртэй танилцах үедээ хэлний бэрхшээл нь хайрлахад саад болдоггүйг ойлгосон юм. Би хүүхдүүдтэй хамт залбирч, инээж, гар урлал хийсэн ба тэднийг гэсэн бүрэн төгс хайрыг мэдрэхгүй байж чадаагүй билээ. Би Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдээ хайрладаг тэрхүү хайрыг зэрвэсхэн харсан бөгөөд тэрхүү баяр баясгалан нь миний зүрх сэтгэлийг дүрслэн хэлэхийн аргагүйгээр дүүргэсэн билээ.

Би бусдад үйлчлэх бүрдээ зөвхөн үйлчилж буй тэднийг гэсэн хайрыг төдийгүй Тэнгэрлэг Эцэгээ хайрлах хайрыг мэдэрдэг. “Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу” (Мозая 2:17) гэсэн зарчим үнэхээр үнэн болохыг би мэдсэн юм. Үйлчлэл нь том эсвэл жижиг байна уу ялгаагүй, миний үйлчлэлийн зорилго бол Бурханыг алдаршуулахын тулд билээ. (Матай 5:16-г үзнэ үү) Намайг бусдад үйлчлэх үед

хүмүүс Тэнгэрлэг Эцэгийг хайрладаг миний хайрыг болон миний дотор асч буй Христийн гэрлийг олж хардаг гэдэгт би найддаг.

Зохиогч нь АНУ-ын Виржинид амьдардаг.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Хайрын хэлхээ

Насанд хүрсэн хэн нэгнээр туслуулан, нэг бүр нь 2,5 см-ын өргөнтэй, 20 см-ын урттай нарийхан хэдэн ширхэг цаас хайчил. Өдөр бүр хэн нэгэнд хайраа үзүүлэх үйлчлэлийг энэ сард хий. Чи эцэг, эхдээ гэр орноо

цэвэрлэхэд нь тусалж эсвэл хөршдөө эелдэг үгтэй зурвас бичиж болох юм.

Өдөр бүр хэрхэн үйлчлэл хийснээ нарийхан цаасан дээр бичээд дараа нь тойрог үүсгэхийн тулд нарийхан цааснуудын үзүүрүүдийг холбон наалдуулдаг туузаар эсвэл цавуугаар наа. Шинэ цааснуудын үзүүрүүдийг нийлүүлэн, наалдуулдаг туузаар эсвэл цавуугаар наахаасаа өмнө нэг шинэ цаасны үзүүрийг өмнөх өдрийн тойргоос гулсуулан татаж, тойргоо холбож болно. Чиний хайрын хэлхээ өсч байгааг анзаараарай! Үйлчлэлийн гинжин хэлхээгээ хоёрдугаар сар дууссан ч үргэлжлүүлэн хийж болно шүү дээ.

© 2014 Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/13. Орчуулгын зөвшөөрөл: 6/13.
First Presidency Message, February 2014. Mongolian.10862 363-ын орчуулга



Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Сайн Хоньчин

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийн тулд эрэлхийл. Аврагчийн амьдрал болон зорилгыг ойлгох нь таны Түүнд итгэх итгэлийг хэрхэн нэмэгдүүлж мөн айлчилж очдог хүмүүсийг тань хэрхэн адислах вэ? Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл reliefsociety.lds.org хаягаар орж үзнэ үү.

Итгэл, гэр бүл, халамж

Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудын тухай айлчлагч багшийн цуврал захиасуудын хэсэг юм.

Сайн Хоньчин, Есүс Христ “Та нарын дундаас хэн чинь зуун хоньтой байтал, нэг нь алдагдахад ерэн есөн хонио бэлчээрт орхин, алдагдсан хонины араас явж, түүнийг олтлоо хайдаггүй вэ? . . .

“Би та нарт хэлье . . . гэмшсэн нэг нүгэлтний төлөө тэнгэрт илүү их баяр хөөр болох болно” (Лук 15:4, 7) хэмээн заасан билээ.

Бид Есүс Христийг Сайн Хоньчин гэдгийг ойлгох үед Түүний жишээг дагах мөн гачигдалтай тэдэнд үйлчлэх бидний хүсэл нэмэгддэг. Есүс “Би бол сайн хоньчин мөн. Би өөрийнхийгөө мэдэх бөгөөд Өөрийнхөн минь Намайг мэднэ.” . . . Би хоньдын төлөө амиа өгнө” (Иохан 10:14–15). Христийн Цагаатгалын ачаар бидний хэн нь ч гэртээ харих замаа мэдэхгүй байхаар төөрөн одохгүй юм (Лук 15-ыг үзнэ үү).

Ерөнхийлөгч Томас С.Монсон “Сүргийг халамжлах нь бидний үүрэг билээ” хэмээн хэлсэн. . . . Бид үйлчлэхээр урагшлах болтугай.”¹

Судруудаас

Дуулал 23; Исаиа 40:11;
Мозая 26:21

Бидний түүхээс

Халамжийн Нийгэмлэгт хамгийн анх оролцсон Элизабет Анн Витни 1830 онд хэрхэн хөрвөгдсөн талаараа ярихдаа: “Би ахлагчдыг сайн мэдээг номлож байхыг сонсмогцоо энэ нь Сайн Хоньчны дуу хоолой байсныг мэдсэн” гэжээ.² Элизабет Сайн Хоньчны дуу хоолойг дагасан бөгөөд баптисм хүртэж, гишүүнээр батлуулжээ.

Бид ч гэсэн Сайн Хоньчны дуу хоолойг сонсож чадах бөгөөд Түүний сургаалуудыг бусадтай хуваалцаж чадна. Ерөнхийлөгч Монсон “Бид бол энэ дэлхий дээрх Их Эзэний хүүхдүүдэд үйлчилж, тэднийг өргөх үүрэгтэй Түүний мутар болсон хүмүүс юм”³ хэмээн хэлсэн.

Хоньчин алдагдсан хоньдоо эрж хайдаг шиг эцэг, эхчүүд төөрөлдсөн хүүхдийнхээ араас явах хэрэгтэй. Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Жэймс И.Фауст (1920–2007) “Дуулгаваргүй хүүхдүүдээ заахдаа

зөв шударга, хичээнгүй, залбиралтай байдаг, зүрх сэтгэл нь шаналсан тэдгээр эцэг, эхчүүд та нарт Сайн Хоньчин тэднийг харж байгаа гэдгийг бид хэлж байна. Бурхан та нарын их гунигийг мэддэг мөн ойлгодог. Найдвар байна” гэж хэлжээ.⁴

Эшлэлүүд

1. Томас С.Монсон, “Тэнгэрлэг гэрүүд, Үүрд мөнхийн гэр бүлүүд,” *Лиакхона*, 2006 оны 6-р сар, 70
2. Элизабет Анн Витни, *Миний хаант улсын охид: Халамжийн Нийгэмлэгийн түүх ба ажил (Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society)* (2011), 128
3. Томас С.Монсон, “Өнөөдөр би хэн нэгний төлөө юу хийв?” *Лиакхона*, 2009 оны 11-р сар, 86.
4. Жэймс И.Фауст, Төөрөөд алга болсон хоньд ч гэсэн үнэ цэнэтэй, *Лиакхона*, 2003 оны 5-р сар, 68.

Би юу хийж чадах вэ?

1. Аврагч бол Сайн Хоньчин гэдгийг мэдэх нь бидний амьдралд хэрхэн амар амгаланг авчирдаг вэ?
2. Бид ямар арга замаар сүмээс “алдагдсан” эсвэл өөр шашинтай хүмүүст үйлчилж чадах вэ?
3. Хүүхдүүд нь сайн мэдээгээр амьдрахгүй байгаа эцэг, эхэд би хэрхэн тусалж чадах вэ?